



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠠᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2022 оны 01 сарын 18 өдөр

Дугаар А/13

Алтай хот

Өмнө нь гэр бүлийн хэрэгцээнд дундаа хамтран өмчилсөн газрыг гэр бүлийн нэг гишүүнд шилжүүлэн өмчлүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.6 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.3 дахь заалт, 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2 дахь хэсэг, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 1 дүгээр зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Аймгийн Засаг даргын захирамжаар гэр бүлийн хэрэгцээнд дундаа газар өмчилсөн иргэдийн хэлцлийг харгалзан хавсралтад дурдсан 2 иргэнд үнэ төлбөргүйгээр шилжүүлэн өмчлүүлсүгэй.

2. Газар өмчлөгчийн хуулийн дагуу хүлээсэн үүргийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Есөнбулаг сумын Засаг дарга (А. Алтанхуяг), Улсын бүртгэлийн хэлтэс (Г. Чүлтэмжамц)-т тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2007 оны А/06 дугаар захирамжийн 60 дахь хэсэг, 2005 оны А/97 дугаар захирамжийн 10 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4. Газар өмчлөх эрх нь сэргээгдсэн иргэдэд хууль тогтоомжид заасны дагуу газар үнэгүй өмчлөх эрхээ эдлэх боломжтой болохыг зөвлөсүгэй.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР



Аймгийн Засаг даргын 2007 оны 01 дугаар сарын 18 ны өдрийн 1198 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

ӨМНӨ НЬ ГЭР БҮЛИЙН ХЭРЭГЦЭЭНД ДУНДАА ХАМТРАН ӨМЧИЛСӨН
ГАЗРЫГ ГЭР БҮЛИЙН НЭГ ГИШҮҮНД ШИЛЖҮҮЛЭХ ЖАГСААЛТ

Д/д	Газраа өмчилж авсан иргэдийн нэрс	Газар өмчлөх эрх шилжүүлэн авч буй иргэний нэр		Регистрийн дугаар	Нэгж талбарын байршил, хаяг	Нэгж талбарын дугаар	Захирамжийн дугаар	Газрын хэмжээ
		Эцэг (эх)-ийн нэр	Нэр					
1	Д. Мандах							
2	У. Дархижав							
3	М. Болдбаатар	Данзан	Болдбаатар	ДЮ89012218	Баяншанд 2-2 тоот	060727137	2007.01.0906	1000.0
4	М. Чойном							
5	Р. Алтайбаатар							
6	Д. Одончимэг							
7	А. Эрдэнэ-Очир	Насан заан	Равжир	ДЖ78032437	Баянхайрхан баг 3-5 тоот	060729060	2005.04.18 97	1219.0
8	А. Эрхэм-Эрдэнэ							